



ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЕРӨНХИЙ
ЗАХИРАЛ Н.ЭРДЭНЭБАЯР ТАНАА

МОНГОЛ УЛС
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,
И-мэйл: comcor@iaac.mn, Вэб сайт: http://iaac.mn

2022.09.11 № 05/465
танай _____-ны № _____-т


Хувийн ашиг сонирхлын урьдчилсан
мэдүүлгийг хянасан тухай

Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн Сувилахуй, үйлчилгээний албаны даргаар томилогдохоор нэр дэвшсэн Жамъянбаатарын Нармандах, Инженер, техникийн тасгийн эрхлэгчээр томилогдохоор нэр дэвшсэн Батзоригийн Додьгалсан нарын хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэгт заасныг үндэслэн хянан үзэхэд тухайн албан тушаалд томилоход ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал одоогоор тогтоогдоогүй болно.

Нэр дэвшигч нар нь тухайн албан үүргийг гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөл байдалд дээрх хуулийн 8 дугаар зүйлд заасан мэдэгдэл, тайлбарыг тухай бүр гаргаж байх, мөн хуульд заасан бусад хориглолт хязгаарлалтыг хэрэгжүүлж ажиллах нь зүйтэй.

Түүнчлэн Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3, Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т заасны дагуу 30 хоногийн дотор хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргахыг анхаарна уу.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДҮН
ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА,
ЭРХЭЛСЭН КОМИССАР



Т.ЭНХБОЛД